

Хөгжмийн зохиолч Ли Ши Шианы “Төгөлдөр хуурын цуврал бүтээл” дэхь “Олон янзын хорчин хүүхэнчүүд”-д хийсэн хөгжмийн шинжлэл

Гэрэлтийн Саруул

(Өвөр Монголын Их сургуулийн Урлагийн дээд сургууль, Өвөр Монгол Хөх хот 010010)

Агуулгийн товч: Ли Ши Шиан нь Өвөр Монголын Их сургуулийн Урлагийн дээд сургуулийн профессор, алдарт хөгжмийн зохиолч юм. Хөгжмийн зохиолч Ли Ши Шиан 1998-2001 онуудад бициж туурвисан “Төгөлдөр хуурын цуврал бүтээл” гэх төгөлдөр хуурт зориулсан цуврал байна. Тус өгүүлэл нь Ли Ши Шианы “Төгөлдөр хуурын цуврал бүтээл” дэхь хоёрдгаар бүлэг болох “Олон янзын хорчин хүүхэнчүүд”-д хөгжмийн шинжлэл хийсэн байна.

Зангилгийн үг: Ли Ши Шиан; Олон янзын хорчин хүүхэнчүүд; хөгжмийн шинжлэл

Хөгжмийн зохиолч Ли Ши Шианы “Төгөлдөр хуурын цуврал бүтээл”-ын тавдугаар бүлэг бол “Олон янзын хорчин хүүхэнчүүд” болно. Түүнд нийт зургаан хэсэгтэй.

1. “Цовоо дэгжин Жүй хуар хүүхэн” – F-dur-C-dur
2. “Номхон зантай Жинжүүр” – F же
3. “Гутралтай Нуунзаяа” – G үи
4. “Зээдэр Наа-наа” – D гүн
5. “Гүн бодлоготой Оюудай” – d-moll
6. “Гоё төрсөн Оюунзандан” – D-dur-A-dur

Өвөр Монголын зүүн хойд зүгт нутагладаг Хорчин аймаг гоё сайхан хүүхнүүдээрээ онцгой сайхан байдаг. Тийм ч учраас эдгээр нутгийн хүүхнүүд өөрийн хүслээр нөхөрт гарахд бэрх, өөр хүний болох хувь заяа түгээмэл тааралддаг байна. Энэ бүлэгт сонгогдсон дээрх дуунуудыг ажиглахад дандаа эмэгтэй хүний тухай дуулсан нь харагдаж байна. Эмэгтэй хүнийг олон талаас нь дүрсэлсэн дуу маш их байлгийн дотроос хөгжмийн зохиолч эдгээр 6 дууг сонгон авсан байна. Агуулгын хувьд давхцалгүйгээр сонгож зургаан өөр эмэгтэйг дүрслэн харуулахыг зорьжээ.

Хамгийн эхний аяз болох “Цовоо дэгжин Жүй хуар хүүхэн” зохиол нь “Хас хуар” дуунаас сэдэвлэсэн байна.

“Жүй хуар” дууны эрэлт:

Хорчин нутгийн онцлогтой дуу юм. Мөн Өвөр Монголын алдарт зохиолч Өлзийсангийн номонд бичигдсэн монгол үндэстний үлгэрт дууг түүний агуулгын бүрэн, бүрэн бусаар нь 4 бүлэгт хуваасан юм. Үүнд: өлгөө дуу, хэлхээ дуу, мөчид дуу, мөчир дуу багтана. Харин “Жүй хуар” дуу нь мөчид дууны төрөлд багтана. Мөчид дуу нь үйл явдал нь бүрэн биш үлгэрт дууг хэлэх ба бас янаг дурлалын тухай өгүүлж болно. Санаж хайрлаж явсан Жүй хуар хүүхэн өөр хүнтэй хуримласанд сэтгэл гутрахдаа энэхүү дууг зохион дуулсан байдаг.

Нотны жишээ


“Хас хуар”[1]




Гурван айзам бүхий 4 тухайлбартай энгийн бүтэцтэй хөнгөн, дэгжин дууг хоёр айзмын өмнөтгөлтэй, 7 айзмын төгсгөлтэй фа-мажороос До мажорт хөг дэвсгэр шилжүүлэн зохиомжилжээ. Энд зохиогч гол сэдэв аялгууны айзам бүрийн эхний нотыг авалгүй өөрөөр хэлбэл за такттай болгон найруулжээ. Үүнийг үнэхээр зохиогчийн арга ухаан гэлтэй. За такт орсоноор “Жүй хуар”-ын үндсэн аялгуу тэс өөр өнгө төрхтэй болно.

Нотны жишээ


“Цовоо дэгжин Жүй хуар хүүхэн”





Бүтцийн хувьд 3 айзамт тухайлбарыг сүүлийн эгшгийг урт барьж нэг айзам сунгасгнаас (4 айзам) өөр өөрчлөлт оруулаагүй байна. Харин цовоо дэгжин дэгжин, бас уян зөөлөн шинжийг гаргахын тулд *staccato*, *legato* татлагыг солбиулан ашиглажээ. Зохиролын хувьд эхний 4 айзам тоникийн суурь дээр, дараагийн 4 айзам D, 3-р тухайлбар эргээд тоник, сүүлийн тухайлбар S-аар дамжаар Т дээр иржээ.

Нотны жишээ “Цовоо дэгжин Жүй хуар хүүхэн” төгсгөлийн хэсэг



Төгсгөл хэсэг Фа мажорын D буюу До мажорт дууссан байна.

Энэ хэсгээс бас нэг дууг сонгож үзье. Уйтгар гунигт автагдсан Нуунзаяа хүүхний гунирхалын тухай дуу нь Өвөр монголд нэлээд түгээмэл тархсан байдаг. “Нуунзаяа” дууны үгийг сийрүүлбэл:

“Нуун голын хөвөөн дээр

Ногтоо чирсэн морь

Номхон зантай Нуунзаяа

Нутгаасаа хол заяажээ” хэмээн дуулдаг байна.



Хэмжээний хувьд урт, тайван намуун аялгуутай, мөчлөг бүрийн төгсгөлийг өргөж төгсгөсөн нь итгэл авралын аягийг санагдуулна. Ганцхан үе хэлбэрийн 8 айзамт дууг хөгжмийн зохиолч бүрэн тогтворгүй сэтгэлийн аясыг доод хоолойд гарч ирэх ля бекарь, си бемолийн байнгынөөрчлөлтөөр илэрхийлсэн байна. Мөн л өмнөтгөл 2 айзам, төгсгөлийн 3 айзмаар эхлэл төгсгөлийг тодоггожээ.

Дууны аяыг төгөлдөр хуурын хувьтай харьцуулбал:

Нотны жишээ

“Гутралтай Нуунзаяа”

Adagio

“Нуунзаяа” дууг зохиогч ямар ч хувиралт, өөрчлөлтгүйгээр авчээ.

“Зээдэр Наанаа” аóóíú ¿ãèéã ñèéð¿¿éáýë:

Тал шиг газраа Зээдэр Наанаа хө

Дуугийн цуглаан нь тэндээ юм Хайдар Наанаа хө

Таван зуун газар гаравч ай даа яах вэ дэ

Тавилан сэтгэл чамдаан юм шүү Зээдэр Наанаа хө

“Зээдэр Наанаа” дууны аяыг сонирхож үзье^[3]:



“Зээдэр Наанаа” дууг зохиогч боловсруулахдаа хоёр гарт аялгууг тэнцүү хувиарлажээ. Уг аялгууг жинхэнэ төгөлдөр хуурын фактур болгож чадсан байна. Энэхүү зохиомж хэмнэлийн хувьд морины явдлыг өөрийн эрхгүй төрүүлнэ.

“Оюудай” дууны үгийг сийрүүлбэл:

Санасанд адилхан санаж уу даа Оюудай хө

Ай хөөе Оюудай хө

Санаа болон сэтгэлдээ шингээчихмээр санасан юм аа хө

Бодсондоо адилхан бодож уу даа Оюудай хө,

Ай хөөе Оюудай хө

Бодлого болон зүрхэндээ болгочихмоор бодсон юм аа хө

“Оюудай” äóóî ãü: ¹³



“Жинжүр” дууны эрэлт


Энэ дуу нь мөн Хорчин нутгийн онцлогтой, янаг дурлалын үлгэрт дуу болно. Өвөр Монголын зүүн хойд орон бол феодалын нийгэмд их нөлөөлөгдсөн орон. Иймээс янаг хайр нь эрх чөлөөгүй болохоор гунигтай дуунууд их олон байдаг.

“Жинжүр” дууны үг

Зансандаан тарьсан жансалай хуараа
 Задраад дэлгэрэхий нь хүлээе аа ха хө
 Жанан дээр мордсон Жинжур ангагаан
 Зээлээд ирэхий нь хүлээеэ

“Жинжүр” дууны эх хувилбарын нот





Олон янзын Хорчин хүүхэнчүүд тавдугаар бүлэгт зохиогч Жүй хуар хүүхнээр хорчин эмэгтэй цовоо дэгжин бөгөөд хайр сэтгэлдээ үнэнчийг, Нуунзаяа хүүхнээр эх нутагтаа гүйдэг морь мэт эх нутаг элгэн саднаа гэсэн сэтгэлийг, Зээдэр Наанаагаар феодалын нийгэмд сэтгэлд нийлсэн хүнтэй ханилж болдоггүй, харин эцэг эхийн шийдвэрээр баян хүнтэй хүчээр суусан ч өөрийн хайр сэтгэлд хичнээн үнэнч байхыг, Оюудайн дүрээр хайр сэтгэлийг тус тус илэрхийлэн түүнийгээ нэг оруулжээ. Цовоо, дэгжин, номхон, гутрал гунигтай, гүн бодлоготой, сайхан төрсөн хорчин эмэгтэйчүүдийн бүхий л дүр төрхийг энэхүү бүлэгт олон янзын зохиомж, хэв шинжээр өгүүлсэн байна. Энэ бол Хорчин монгол эмэгтэйн дуулал болж чаджээ.

Зүүлт

[1] “Хорчин ардын дуу” 1983, Тун Лео хот

[2] “Хорчин ардын дуу” 1983, Тун Лео хот

[3] “Хорчин ардын дуу” 1983, Тун Лео хот

Зохиогчийн товч танилцуулга: Гэрэлтийн Саруул (1972-) ,эмэгтэй,Монгол үндэстн, Өвөр Монголын Хорчин баруун гарууи дундад хушууны хүн. Өвөр Монголын Их сургуулийн Урлагийн дээд сургуулийн багш,төгөлдөр хуурын хөгжмийн талаар голчлон судлалж буй.

Тус эх бичгийг 2011-10-15-д олов.